



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№104 /548/

2023.06.27

Цаг үе, үйл явдал

БҮХ ЦЭРГИЙН ИХ ХАР СҮЛДИЙГ ЦЭНГҮҮЛЭН ТАЙХ ЁСЛОЛ БОЛЛОО



Билгийн тооллын 17 дугаар жарны "Үзэсгэлэнт" болгогч хэмээх харагчин туулай жилийн зуны дунд шар морь сарын шинийн 7-ны хүчин төгсөх барилдлагатай хоёр хар Хөх бар энэ өдрийн морин цагт Бүх цэргийн Их хар сүлдийг цэнгүүлэн тайх ёслол Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг, туг сүлдний зохилдлоготой Агуйт ууланд боллоо.

Бүх цэргийн Их хар сүлдийг цэнгүүлэн тайх ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх болон Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба тэргүүтэй БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын удирдлагууд оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх болон Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын дарга нар Агуйт уулын тахилгат овоонд хадаг өргөснөөр Их хар

сүлдийг төрийн цэргийн дүрмийн дагуу Агуйт уулын оргилд, өмнө, дорно, өрнө, умрын элч сүлдийн хамт тусгайлан зассан суудалд байрлуулж, цэнгүүлэн тайх ёслол үйлдэв.

Бүх цэргийн Их хар сүлдэнд өчил өчиж байх үеэр харваач тайлгын их нумаар "Өрсөх дайсан болгоныг өвдөг сөгдүүлэн номхотгож байна" хэмээн шившиж, гурван сум тавих зэрэг ёслол болов.

Өчил дуусахад Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх Бүх цэргийн Их хар сүлдэнд шүүс өргөж, мөргөлөө. Төрийн хонжины командаар ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба цэргийн тангараг уншиж, оролцогчид давтан хэлэв.

Дараа нь Монгол Улсын төрийн дуулал эгшиглэж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба нар Бүх цэргийн Их хар сүлдэнд сөгдөн адис авав. Тайлгад оролцогчид мөн энэ ёсыг үйлдэж Их хар сүлдийг цэнгүүлэн

тайх тайлгын ёслол өндөрлөв.

"Бүх цэргийн Их хар сүлдийг туурга тусгаар Монгол Улсын Төр, цэргийн сүр хүчний бэлгэдэл, сүсэглэн дээдлэх оройн дээд шүтээн гэж үздэг. Бүх цэргийн хар сүлдийг цэнгүүлэх тайлга, цагаалах тайлга гэж бий.

Цэнгүүлэх тайлгыг хоёр жилд нэг удаа, зуны дунд сард туг сүлдний зохилдлоготой өдөр хийдэг бол цагаалах тайлгыг жил бүрийн хаврын тэргүүн сарын шинийн гурванд өргөөнд нь зохион байгуулдаг юм.

Хар сүлдийг цэнгүүлэх тайлгыг Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг, туг сүлдний зохилдлоготой "Агуйт" ууланд үйлдэж байна. Энэхүү уул нь Баянзүрх хайрханы салбар уул юм. Энэ бол түүхэн дурсгалтай, түүхэнд холбогдох олон баримттай нутаг юм. Ард нь Чингис уул, Тулгаг гурван гацаа буюу Тулуйн төрсөн газар бий гэдэг. Энэ хавьд Чингис хааны түмэн хишигтэн цэргүүд байрлаж байсан, их хааны ташуур олдсон газар гэж түүхэнд тэмдэглэгдсэн онцлогтой газар юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 15	🌧️ 7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	🌧️ 24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,429	3,435
EUR 🇪🇺	3,740	3,755
CNY 🇨🇳	477	479.50
RUB 🇷🇺	39,50	40.50
JPY 🇯🇵	23.90	24.55
KRW 🇰🇷	2.62	2.64

ЗУРХАЙ

2023.06.27 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 9

**ЗУНЫ ДУНД ШАР МОРЬ САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ
УЛААН ЛУУ ӨДӨР**

Үс засуулбал:
Өвчин өчүүхэн ирнэ
Наран ургах, шингэх:
04.55-20.55
Барилдлага:
Хүчин төгсөх
Шүтэн барилдлага:
Хуран үйлдэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс элзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

"ХААНЫ ЭРЭЛД-2023"-ЫН ЭРГЭН ТОЙРОНД...



"Хааны эрэлд" энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургууль нь 2003 онд анх АНУ болон Монгол Улсын хамтарсан хээрийн сургуулиар эхэлсэн бөгөөд 2006 оноос олон улсын статустай болж 20 дахь жилдээ ийнхүү зохион байгуулагдаж байна.

АНУ-тай хамтран зохион байгуулдаг "Хааны эрэлд" энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургуульд өнгөрсөн хугацаанд дэлхийн 67 улсын 18 мянга гаруй цэргийн алба хаагч оролцсон байна.

Тус сургууль нь оролцогч улс орнуудын энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх, найрамдал нөхөрлөл, хамтын ажиллагаа, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулдаг ач холбогдолтой.

Энэ удаагийн сургуульд нийт 26 орны 1100 гаруй цэргийн алба хаагч оролцож байгаа бөгөөд үүнээс Бүгд Найрамдах Лаос Ард Улс болон Бүгд Найрамдах Турк Улс анх удаа цэргээ илгээсэн юм.

"Хааны эрэлд-2023" энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургууль нь команд-штабын болон салаадын хээрийн сургууль, чадавхыг нэмэгдүүлэх сургалт гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэж байна.

Түүнчлэн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны бүтцийн нэг болох цагдаагийн бүрэлдэхүүний төлөөлөл оролцож буй бөгөөд тэдгээр төлөөлөл нь өмнө нь БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн Монгол

Улсын цагдаагийн алба хаагч нар юм.

Мөн олон улсын "Улаан загалмай" нийгэмлэгийн төлөөлөгчид оролцож байна. Улс орон бүр алба хаагчдаа бодит цагийн байдалд дадлагажуулахын тулд зохиомол улс, хотын захирагч, цэргийн захирагч, эмч зэрэг дүрд хувирч байгаа бөгөөд бусад оролцогч НҮБ-ын хүмүүнлэгийн байгууллага болон ТББ-ын дүрийг бүтээж байгаа юм.

Түүнчлэн гар хийцийн тэсэрч дэлбэрэх төхөөрөмжөөс хамгаалах, түүний эсрэг арга хэмжээ авах талаар мэргэшсэн олон улсын багш нар хамтран ажиллаж байна.

Салаадын хээрийн сургуулийн хувьд хичээлийн 9

цэгт НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүсдэг бодит цагийн байдалд дүйцүүлэн хичээл сургуулиа зохион байгуулж байгаа юм. Гурав дахь хичээл болох чадавхыг нэмэгдүүлэх сургалт зөвхөн АНУ болон Монгол Улсын цэргийн алба хаагчдын дунд зохион байгуулагдаж байгаагаараа онцлог юм.

Бүс нутагтаа томоохонд тооцогдох "Хааны эрэлд" сургууль бодлого, төлөвлөгөөгөө амжилттай биелүүлж даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлын төлөө хүчин зүтгэх мянга мянган чадварлаг энхийг сахиулагчийг ийнхүү сургаж бэлтгэж байна.

Ахмад ГИТГЭЛТ



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,857,685

Эдгэрсэн

Нийт: 663,358,133

Нас барсан

Нийт: 6,894,561

Цахим шууданд

ХААНЫ ЭРЭЛД СУРГУУЛИЙН СОЁЛЫН ӨДӨРЛӨГИЙН ХҮРЭЭНД



уламжлалтай билээ.

Уг ажлын хүрээнд энэ сарын 27-ны өдөр АНУ -ын цэргийн алба хаагчид өөрсдийн өв соёлоо бусад орны цэргийн алба хаагч нарт сурталчлан таниулж, өөрсдийн үндэсний спорт болох Америк хөл бөмбөгийг бусад орны цэргийн алба хаагчидтай хамтран тоглож, тэдэнд зааж сурган нэгэн оройг спортоор нөхөрлөн өнгөрүүлээ.

Ахмад ГИТГЭЛ



“Хааны эрэлд 2023” энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургуулийн төлөвлөгөөний дагуу тус сургуульд оролцож буй цэргийн алба хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, орон орны цэргийн алба хаагчид өөрсдийн орны үндэсний соёл, урлаг, спорт арга хэмжээг бие биедээ сурталчлан танилцуулдаг

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТАМИРЧИН Д.ЦОГЗОЛМАА АЗИЙН АВАРГААС ХҮРЭЛ МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ



барилдан ялагдсан бөгөөд хүрэл медалийн төлөө Казахстан Улсын бөхтэй барилдан 7:6 харьцаагаар ялалт байгуулж хүрэл медаль хүртсэн юм.

Д.Цогзолмаа нь Зэвсэгт хүчний 326 дугаар ангид ахлагчийн албан тушаалд энгийнээр ажилладаг тэргүүний ажилтан албан хаагч төдийгүй Монгол Улсын чөлөөт бөхийн шилдэг тамирчны нэг юм.

Ахмад Ц.ТУНГАЛАГ



Киргизстан Улсын Бишкек хотод зохион байгуулагдсан “U23” насны Азийн аварга шалгаруулах тэмцээний эмэгтэйчүүдийн 72 кг-ын жинд Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн тамирчин, ОУХМ Д.Цогзолмаа хүрэл медаль хүртлээ. Тэрээр тэмцээний эхний тойрогт Тайланд хоёрдугаар тэмцээний эмэгтэйчүүдийн 72 кг-ын жинд Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн тамирчин, ОУХМ Д.Цогзолмаа хүрэл медаль хүртлээ. Тэрээр тэмцээний эхний тойрогт Казахстан Улсын бөхчүүдтэй барилдан ялалт байгуулж, хэсгийн аваргын төлөө БНХАУ-ын бөхтэй

Гэрэл зураг түүх өгүүлнэ



Эзэнтэйгээ хамт үүрэг гүйцэтгэсэн хүлэг морьддоо хүндэтгэл үзүүлэв

ЦЭРГИЙН ЭРДЭМД ШАМДАН СУРАЛЦАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн Сургалтын төвд хангайн бүс буюу Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Орхон аймгийн 100 гаруй оюутан цэрэг цэргийн эрдэмд шамдан суралцаж байна. Сургалтад хамрагдаж байгаа оюутан цэргүүд танхимын сургалтаар олж авсан онолын мэдлэгээ бататгахын зэрэгцээ сэтгэл зүйн байдал өндөр, эрч хүчтэй байгаа нь уулзалт, ярилцлагаар илэрч байлаа.

Тэдэнд сэтгэл зүйн бэлтгэл, хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол хийж, эрүүл мэндийн байдалд үзлэг, зөвөлгөөг тухай бүр нь өгч ажиллаж байна.

Мөн “Оюутан цэрэг” сургалт нь ангийн залуу манлайлагч офицер, ахлагч нарыг түшиглэн зохион байгуулагдаж байна.

Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 338 ДУГААР АНГИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХОЁРДУГААР ШАТНЫ ҮЗЛЭГТ ХАМРАГДЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох хоёрдугаар шатны үзлэгт хамрагдлаа.

Тус үзлэгийг Удирдах газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг цэргийн алба хаагчдын ёс

зүй, дүрэмч-жагсаалч байдал, сэтгэл зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн бэлэн байдлын түвшинг тогтоох чиглэлээр үзлэгийг явуулж цэргийн сургалт бэлтгэлийн явц, чанар, орчин нөхцөл, өнөөгийн байдлыг бодитоор тогтоож, цаашид цэргийн алба хаагчдад чиглэсэн сургалт бэлтгэлийг сайжруулах чиглэлээр үнэлэлт, дүгнэлт өглөө.

Ахмад Б.ОДБАЯР

